



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/09


Хужирт сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2,7 дугаар хавсралт, 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралт, Монгол Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоол, 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нарын албан тушаалын цалинг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэгдсэн цалинг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газрын цалингийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ